



## ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалт, Шадар сайд, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх Байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 дугаар, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/43, А/508 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ЦССҮТ-ийн ажиллах журам”-ыг 1 дүгээр, үйл ажиллагааны хэрэгжилтийн хяналт үнэлгээний Тайлангийн маягтын загварыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Шуурхай удирдлагын нэгжийн орлогч дарга /Ч.Батболд/-д даалгасугай.

3. Журамтай уялдуулан “ЦССҮТ-ийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-нд тодотгол хийхийг Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн Нарийн бичгийн дарга /Ч.Далайцэрэн/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР




МОНГОЛЫН БИШГЭЭЛЭЛЭГ  
УЛСЫН БИШГЭЭЛЭГ  
ТУШААЛ

Хугацаа: \_\_\_\_\_

Тусгай: \_\_\_\_\_

Төрөл: \_\_\_\_\_

Боловсруулсан: ..... Ч.Далайцэрэн  
Хянасан: ..... Я.Тогтохням  
Нийлсэн: 2хувь.



**ГАМШИГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ БАЙДЛЫН ҮЕД  
ЦССҮТ-ИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

**Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Шадар сайд, Байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 дугаар, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/43, А/508 дугаар тушаалыг тус тус үндэслэн Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын улмаас хүн амын эрүүл мэндэд хохирол учрахаас урьдчилан сэргийлэх, болзошгүй гамшиг осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед цус, цусан бүтээгдэхүүний хангамжийн бэлэн байдал, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг цусны албаны хэмжээнд хэрэгжүүлэхэд ЦССҮТ-ийн “Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн” - ний гүйцэтгэх чиг үүрэг, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлох, байгууллага дундын харилцан ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн дарга нь ЦССҮТ-ийн Ерөнхий захирал байна.

1.3. Өдөр тутмын бэлэн байдлын үед ЦССҮТ-ийн гамшгийн өмнөх үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн нарийн бичгийн дарга мөн ангийн даргын өмнө хариуцна.

1.4. Өндөржүүлсэн болон бүрэн бэлэн байдлын үед эрхэлсэн асуудлын хүрээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Тохиолдлын удирдлагын нэгж” ажиллана.

1.5. Улсын албаны удирдлагад ажиллах Тохиолдлын удирдлагын нэгжийг ангийн орлогч дарга удирдана.

1.6. Тохиолдлын удирдлагын нэгж нь ЦССҮТ-ийн нэгжүүдийг тохиолдлын удирдлага, мэргэжил арга зүйгээр хангана.

1.7. Тохиолдлын удирдлагын нэгж нь Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн Улсын албаны үйл ажиллагаатай уялдуулж гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, мэдээ, мэдээлэл солилцох, бэлэн байдлыг хангах, эрсдэлийн үнэлгээ, тохиолдлын удирдлагын тогтолцоонд суурилсан хариу арга хэмжээг зохион байгуулах, эрсдэлийн харилцаа холбоог зохицуулах, нөөц бүрдүүлэх, сургалт, дадлага зохион байгуулах зэрэг арга хэмжээг тогтмол авч

хэрэгжүүлнэ.

1.8. Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, эрсдэлийн үнэлгээ хийж, хариу арга хэмжээг Монгол улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаалын дагуу зохион байгуулна.

## ХОЁР. ГАМШИГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ БАЙДЛЫН ҮЕД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ЧИГ ҮҮРЭГ

2.1. Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн Улсын албанаас гамшгаас хамгаалах чиглэлээр гаргасан шийдвэрийг хэрэгжүүлнэ.

2.2. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед дэмжлэг үзүүлэх мэргэжлийн анги нь энэ журмын 2.3, 2.4, 2.5-д заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.3. Гамшгийн өмнөх үйл ажиллагааны чиглэлээр:

2.3.1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан чиг үүрэг

2.3.2. гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, техник, хэрэгслийн бэлэн байдлыг хангах;

2.3.3. онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, бусад албадтай харилцан ажиллах төлөвлөгөө боловсруулж, батлуулах;

2.3.4. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-д заасны дагуу гамшгийн эрсдэлийг бууруулахад шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж, зарцуулах;

2.3.5. гамшгийн эрсдэлийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх, үнэлгээнд үндэслэн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, мэдээ, тайлан гаргах;

2.3.6. гамшгаас хамгаалах чиглэлээр албаны тэмдэглэл, даалгавар, удирдамж гаргах, биелэлтийг шалгах, ЦССҮТ-ийн хүрээнд баримтлах журам, заавар боловсруулж батлуулан хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн хяналт үнэлгээ хийх;

2.3.7. гамшиг, осол, халдварын голомтод үүрэг гүйцэтгэх албан хаагчдыг тусгай хувцас, хүн нэг бүрийн болон хамтын хамгаалах хэрэгслээр хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартын дагуу ажиллах нөхцлийг бүрдүүлэх;

2.3.8. ЦССҮТ-ийн хэмжээнд болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний сургалт, дадлага сургуулилтыг хийх

2.3.9. салбар, байгууллага хоорондын шуурхай мэдээллийг харилцан солилцож байх;

2.4. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн ажиллагааны чиглэлээр Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан чиг үүргээс гадна дараах үүргийг хэрэгжүүлж ажиллана:

2.4.1. Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн Улсын албыг мэргэжлийн заавар, зөвлөмж, мэдээ мэдээллээр цаг тухайд нь шуурхай хангах;

2.4.2. гамшиг болон аюулт үзэгдэл, осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ЦССҮТ-ийг ажлын тусгай горим болон гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, гамшгийн голомтын бүсэд хүч хэрэгслийг шуурхай томилон ажиллуулах;

2.4.3. гамшиг, осол, халдварын голомтод үүрэг гүйцэтгэх албан хаагчдыг тусгай хувцас, хүн нэг бүрийн болон хамтын хамгаалах хэрэгслээр хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартын дагуу ажиллах нөхцлийг бүрдүүлэх;

2.4.4. гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах Эрүүл мэндийн тусламжийн мэргэшсэн баг (EMT – Emergency medical team) -ийн сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулах;

2.4.5. гамшиг, ослын үед ажиллах хээрийн болон явуулын цус цуглуулах төвийн журмыг батлуулан бусад цусны салбар төв, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.4.6. Гамшиг, осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээг удирдан зохицуулах чиг үүрэг бүхий нэгж ажиллуулах

2.5. Гамшгийн дараах сэргээн босгох, гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааны чиглэлээр:

2.5.1. Хохирлын хэмжээг тооцох

2.5.2. Эрүүл мэнд, халдваргүйтгэлийн багтай үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллана.

Гурав: ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН НЭГЖИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Тохиолдлын удирдлагын нэгж нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. ЦССҮТ-ийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийлгэх, хяналт тавих,

3.1.2. гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын аюулаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй арга хэмжээнд татан оролцуулах, техник, материал, хэрэгсэл зэрэг тухайн албанд шаардагдах нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг <sup>3</sup>

хангах, хяналт тавих;

3.1.3. эрсдэлийг бууруулах, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед цусны албаны тогтвортой ажиллагааг хангах ажлыг зохион байгуулах;

3.1.4. гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, мэдээллийг орон нутгийн цусны салбаруудаас гаргуулан авах, мэдээллийн сан бүрдүүлэх

3.1.5. гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын нөхцөл байдлыг үнэлж, дүгнэх, гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

3.1.6. гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын зарлан мэдээллийг тодотгох, сургалт сурталчилгаа зохион байгуулах, сургалтын материал, гарын авлага боловсруулах;

3.1.7. эрүүл мэндийн бусад байгууллага болон онцгой байдлын байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөөнд жилд нэгээс доошгүй удаа, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тухай бүр гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, харилцан ажиллагааг зохион байгуулах;

3.1.8. гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн үнэлгээний түвшин, тохиолдлын удирдлагын тогтолцоонд суурилсан хариу арга хэмжээ, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах;

3.1.9. гамшгийн голомтод ажилласан албан хаагчдын ажлын үр дүнг харгалзан урамшуулах санал гаргах;

3.1.10. авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээг Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн Улсын албанд хагас, бүтэн жилээр гаргаж хүргүүлэх.

#### Дөрөв. ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН НЭГЖИЙН БҮРЭЛДЭХҮҮН

4.1 Нэгж нь дараахь бүрэлдэхүүнтэй байна:

4.1.1 нэгжийн дарга – Ерөнхий захирал

4.1.2 нэгжийн орлогч – СТСБА-ны дарга

4.1.3 гамшгаас хамгаалах асуудал хариуцсан албан хаагч - МТИТТ-ийн

Мэдээллийн технологийн инженер

4.1.4 холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан - ТТ-ийн олгох хэсгийн сувилагч

4.1.5 төлөвлөлт хариуцсан ажилтан Нэгдсэн лабораторийн эрхлэгч

4.1.6 Бэлэн байдал, эрсдэлийг бууруулах, сургалт, сурталчилгаа, хариуцсан ажилтан – Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга

4.1.7 мэргэжлийн ангийн бэлтгэл, хариу арга хэмжээ хариуцсан ажилтан


– Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч, Хүний нөөцийн ажилтан, хуулийн зөвлөх

4.1.8 санхүү, хангалт хариуцсан ажилтан – СТСБА-ны Нярав

4.1.9 хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан – Халдвараас сэргийлэх багийн ахлагч

4.1.10 эрсдэлийн үеийн харилцаа холбоо хариуцсан ажилтан – НЛТ-ийн Лаборант Д.Энхсүрэн

# ГАМШИГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ БАЙДЛЫН ҮЕД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН УДИРДЛАГЫН БҮРЭЛДЭХҮҮН





4.2. Тохиолдлын удирдлагын нэгжийн даргын эзгүйд нэгжийн орлогч дарга түүний ажлыг орлох бөгөөд ажилтнуудын орлон ажиллах хуваарийн дагуу тухайн орлох албан тушаалтан орлож ажиллана.

4.3 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын онцлог, төрлөөс шалтгаалан нэгжийн орлогч дарга болон менежерийг өөрчлөн томилж болно.

4.4 Нэгжийн бүрэлдэхүүн, орлох албан тушаалтнууд уг тушаалын 2 дугаар хавсралтанд заасан ажил үүргийн хуваарийн дагуу ажиллана. Шаардлагатай тохиолдолд ЦССҮТ-ийн орон тооны бус баг, хороо, зөвлөлийн төлөөллийг нэмэлтээр татан оролцуулж болно.

4.5 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын төрөл, эрсдэлийн түвшингээс хамаарч Тохиолдлын удирдлагын нэгж хэсэгчлэн буюу бүхэлдээ идэвхжиж ажиллаж болно.

4.6 Нэгжийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд нөхөн томилгоо хийж холбогдох ажилтнуудад тухай бүр мэдэгдэнэ.

#### Тав: ГАМШИГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ, НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1 ЦССҮТ нь болзошгүй гамшиг, осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэнэ:

5.1.1 эрүүл мэндийн байгууллагын болон салбар дундын мэдээ мэдээлэл солилцох;

5.1.2 эрсдэлийн үнэлгээ хийх;

5.1.3 эрсдэлийн үнэлгээнд үндэслэн төлөвлөлт хийх;

5.1.4 гамшигийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах сургалт зохион байгуулах;

5.1.5 ангийн удирдлагын бүрэлдэхүүний сургалт, ширээний дасгал сургалт, дадлага сургуулилтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;

5.1.6 болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын мэдээллийн сан бүрдүүлэх;

5.1.7 эрсдэлийн үеийн харилцаа холбоо, хяналт үнэлгээ, тайлагналт зэрэг үйл ажиллагаанууд багтана.

5.2. Гамшиг, осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед тохиолдлын удирдлагын нэгж дараах хариу арга хэмжээ, нөхөн сэргээх арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажиллана:

5.2.1. Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан эрсдэлийн үнэлгээ “өндөр”, “маш өндөр” түвшинд үнэлэгдсэн үед Тохиолдлын удирдлагын нэгж идэвхжиж, тохиолдлын удирдлагын тогтолцооны дагуу ажиллаж эхэлнэ.

5.2.2. үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллагаас үйл явдлын мэдээлэл, эрсдэлийн үнэлгээний тайланг авна.

5.2.3. тохиолдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005) болон энэхүү журмыг нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын эрт, сэрэмжлүүлэг хариу арга хэмжээг зохицуулсан холбогдох бусад заавар, журмын хамт мөрдлөг болгоно.

5.3. Тохиолдлын удирдлагын тогтолцооны үйл ажиллагаа дараах үндсэн зарчимд суурилна:

5.3.1. шаталсан удирдлагын тогтолцоотой байх (бие бүрэлдэхүүний тайван цагийн албан тушаалын зэрэглэл, шатлал Тохиолдлын удирдлагын тогтолцоо идэвхжсэн үед үйлчлэхгүй);

5.3.2. бүх төрлийн эрсдэлийн хариу арга хэмжээнд тохирсон нэгдсэн бүтэц, загвартай байх;

5.3.3. нөхцөл байдлын өөрчлөлтөд мэдрэг, уян хатан байх.

5.4. Тохиолдлын удирдлагын нэгж нь зохицуулагч, менежер, эрсдэлийн харилцаа холбоо, нөөц, санхүү, төлөвлөлт, тархвар зүй, шуурхай хариу арга хэмжээний багуудаас бүрдэнэ. Шаардлагатай үед 7/24 цагаар уртасгасан цагаар ажиллана.

5.5. Онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний нэгдмэл байдлыг хангах үүднээс үүссэн нөхцөл байдал, эрсдэлийн төрлөөс үл хамааран Зохицуулагч, эрсдэлийн харилцаа холбооны баг, нөөц, санхүүгийн багийн гишүүд **байнгын** бүрэлдэхүүнтэй байна. Харин Менежер, төлөвлөлт, хариу арга хэмжээний багийн бүрэлдэхүүнийг эрсдэлийн төрөл бүрт **ялгаатай** томилж болно.

5.6. Тохиолдлын удирдлагын нэгжийн бие бүрэлдэхүүн нь 2 цагийн дотор цугларна.

5.7. Тохиолдлын удирдлагын нэгжийн бие бүрэлдэхүүнд ажиллах ажилтнуудтай холбоо тогтоох боломжгүй (эзгүй, эрсдэлд өртсөн г.м) тохиолдолд орлон ажиллах ажилтныг дайчлан ажиллуулна.

5.8. Дээрх ажилтнуудтай холбоо тогтоох боломжгүй тохиолдолд Тохиолдлын удирдлагын нэгжийн менежерийн шийдвэрээр тухайн чиглэлээр мэргэшсэн, туршлагатай, олон жил ажилласан мэргэжилтнийг сонгон ажиллуулна.

## Зургаа. ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЧИГ ҮҮРЭГ

6.1. Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь үүссэн нөхцөл байдал, эрсдэлийн төрөл, түвшнээс үл хамааран дараах байдлаар загварчлагдсан бүтэцтэй байна **(Хүснэгт 1-5)**.

6.1.1 хариу арга хэмжээний зохицуулагч (цаашид Зохицуулагч гэх)

6.1.2 хариу арга хэмжээний менежер (цаашид менежер гэх)

6.1.3 төлөвлөлтийн баг

6.1.4 хариу арга хэмжээний баг

6.1.5 эрсдэлийн харилцаа холбооны баг

6.1.6 санхүү, нөөцийн баг

### 6.2. Зохицуулагчийн үндсэн чиг үүрэг :

6.2.1. тохиолдлын удирдлагын тогтолцооны зохицуулагч нь Тохиолдлын удирдлагын нэгжийн дарга байна.

6.2.2. хариу арга хэмжээний ерөнхий удирдлагыг ханган, багуудын үйл ажиллагаа болон хүний нөөцийн төлөвлөлтийг уялдуулан зохицуулах;

6.2.3. хариу арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой үүрэг, даалгаврыг менежерт өгөх;

6.2.4. тохиолдлын удирдлагын тогтолцооны бүх бүрэлдэхүүн хэсгийн оролцоо бүхий өдөр тутмын шуурхай хуралдааныг удирдах, бие бүрэлдэхүүний оролцоог хангах;

6.2.5. хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэхтэй холбоотой бусад салбарыг мэдээллээр хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

6.2.6. нэгжийн дарга үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээллээр Эрүүл мэндийн Улсын албыг тогтмол ханган ажиллах;

6.2.7. тохиолдлын удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүнийг өргөжүүлэх, багасгах шийдвэрийг гаргах;

6.2.8. тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхжүүлэх, уг шийдвэрийг цуцлах, хариу арга хэмжээний удирдлагыг шилжүүлэх шийдвэр гаргах;

6.2.9. хариу арга хэмжээнд шаардлагатай зардлыг төлөвлөх, зарцуулах шийдвэрийг гаргаж, хяналт тавих;

6.2.10. үүссэн нөхцөл байдал, хариу арга хэмжээний явц үр дүнгийн талаарх албан ёсны мэдэгдлийг олон нийтэд хандан хийх;

6.2.11. мэдээлэл, сургалт сурталчилгааны материалыг олон нийтэд түгээх зөвшөөрөл өгөх;

6.2.12. хариу арга хэмжээний нэгдсэн тайланг баталгаажуулах.

### **6.3. Менежерийн үндсэн чиг үүрэг:**

6.3.1. менежер нь тухайн эрсдэлийн асуудлыг хариуцсан Тохиолдлын удирдлагын нэгжийн орлогч дарга байна.

6.3.2. багуудын үйл ажиллагааг тодорхойлох, уялдуулан зохицуулах;

6.3.3. хэрэгжүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тогтоож, хариу арга хэмжээг төлөвлөн удирдах;

6.3.4. багуудын үйл ажиллагааны үр дүнг нэгтгэн, тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэн, Зохицуулагчид тайлагнах, зохих шийдвэрийг гаргуулах;

6.3.5. тохиолдлын удирдлагын тогтолцооны багуудын өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах;

6.3.6. шинээр дайчлагдсан ажилтнуудад хийх ажлын чиглэл, удирдамжийг танилцуулах;

6.3.7. багийн гишүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах;

6.3.8. эрсдэлийн үеийн харилцаа холбооны бүх төрлийн мэдээллийн агуулгыг хянан баталгаажуулах.

### **6.4. Төлөвлөлт, тархвар зүйн багийн үндсэн чиг үүрэг:**

6.4.1. хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг шуурхай боловсруулан нэгжийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулах, тодотгол хийх;

6.4.2. холбогдох асуудлуудыг нэгжийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг зохицуулагч, менежерт тавьж шийдвэрлүүлэх;

6.4.3. төлөвлөлт хийхэд шаардлагатай бүх төрлийн мэдээллийг мэргэжлийн байгууллагууд, эрх бүхий албан тушаалтнаар дамжуулан өдөр тутам авах;

6.4.4. өдөр тутмын шинэчлэгдсэн мэдээлэлд үндэслэн эрсдэлийн үнэлгээ хийж, авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний талаар менежер, зохицуулагчид өдөр тутам танилцуулах;

6.4.5. өдөр тутмын шинэчлэгдсэн мэдээллийг бэлтгэн хянуулж, эрсдэлийн харилцаа холбооны баг болон холбогдох байгууллагад хүргүүлэх;

6.4.6. үүссэн нөхцөл байдалтай холбоотой бүхий л мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх, хэтийн төлвийг гаргах;

6.4.7. хариу арга хэмжээний чиглэл, цар хүрээ, шаардагдах нөөцийг (эм, урвалж, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, хүний нөөц, техник хэрэгсэл; хувийн хамгаалах хувцас хэрэгсэл гм) төлөвлөх;

6.4.8. хариу арга хэмжээний явц, үр дүнг тогтмол хянан мэргэжил аргазүйн удирдлагаар хангах;

6.4.9. хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай заавар, журам, түр заавар, албаны тэмдэглэл зэрэг бодлогын болон техникийн баримт бичгийг боловсруулах, батлуулах;

6.4.10. шаардлагатай тохиолдолд нөхцөл байдлыг тандах зорилгоор нэмэлт мэдээлэл цуглуулах;

6.4.11. шаардлагатай тохиолдолд хөл хорио, хязгаарлалтын дэглэм тогтоох санал хүргүүлэх;

6.4.12. багийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, бичгийн хэрэгсэл бусад эд зүйлсийн хүсэлтийг нөөцийн багт тавьж шийдвэрлүүлэх;

6.4.13. хариу арга хэмжээний тайланг нэгтгэх, дэгдэлтийн хариу арга хэмжээний хурлыг зохион байгуулах.

#### **6.5. Хариу арга хэмжээний багийн үндсэн чиг үүрэг:**

6.5.1. хариу арга хэмжээний төлөвлөгөөний өдөр тутам хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

6.5.2. үйл явдлын тархалт, өрнөл, эрсдэлийн судалгаа хийх;

6.5.3. голомтод хариу арга хэмжээг зохион байгуулах, эрсдэлийг бууруулах, голомтыг цомхотгох арга хэмжээ авах;

6.5.4. мэргэжлийн төв байгууллагаас томилогдон ажиллаж буй шуурхай хариу арга хэмжээний багуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

6.5.5. дайчлагдан ажиллаж буй бие бүрэлдэхүүнийг өртөлтийн өмнөх болон дараах урьдчилан сэргийлэлтэд хамруулах, эрүүл мэндийг нь хянах ажлыг зохион байгуулах;

6.5.6. бүх багийг өдөр тутмын мэдээллээр тогтмол хангах;

6.5.7. хариу арга хэмжээнд зарцуулах нөөцийг хуваарилах;

6.5.8. өдөр тутмын хэрэгжүүлсэн арга хэмжээг дараагийн өдрийн шуурхай хуралд тайлагнах;

#### **6.6. Эрсдэлийн харилцаа холбооны багийн үндсэн чиг үүрэг:**

6.6.1. үүссэн нөхцөл байдалтай уялдуулан олон нийтэд мэдээлэл хийх;

6.6.2. өдөр тутмын үйл ажиллагааны шинэчилсэн мэдээллийг бэлтгэх, танилцуулах;

6.6.3. хүн амын дундах хандлага, ойлголтын судалгааг хийх, залруулга мэдээлэл бэлтгэн гаргах;

6.6.4. хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа мэдээнд дүн шинжилгээ, мониторинг хийж, цаашдын чиглэлийг боловсруулах;

6.6.5. иргэд, олон нийтийн санаа бодлыг сонсох нээлттэй утас ажиллуулах;

6.6.6. эрүүл мэндийн албаны цахим хуудас, фейсбүүк хуудсаар дамжуулан хүн амыг мэдээллээр тогтмол хангах;

6.6.7. зорилтот бүлгийн хүн амыг тогтоох, мэдээллийн хэрэгцээг тодорхойлох;

6.6.8. олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг үнэн зөв, бодитой мэдээллээр тогтмол хангах;

6.6.9. хүн амд чиглэсэн сэрэмжлүүлэг, санамж, зөвлөмж, мэдээлэл, сургалт сурталчилгааны материалыг бэлтгэх, түгээх;

6.6.10. олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийх хуваарь гарган батлуулж, хэрэгжүүлэх;

6.6.11. хэвлэлийн бага хурал (идэвхжлийн, явцын, цуцалсаны дараах)-ыг зохион байгуулах;

6.6.12. олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, нийгмийн харилцааны сүлжээгээр цацагдаж байгаа үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээллийг шүүх, хариу мэдэгдэл хийх шаардлагатай мэдээллийг менежерт танилцуулах;

6.6.13. олон улсын байгууллагад үйл явдлын талаарх болон хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээллийг тогтмол хүргүүлэх;

6.6.14. хариу арга хэмжээний үед ашигласан мэдээлэл, сургалт сурталчилгааны материалыг цахим болон цаасан хэлбэрээр хадгалах, архивлах;

6.6.15. хариу арга хэмжээний сайн туршлага, манлайлан ажиллаж буй ажилтнууд болон эрсдлийг даван туулсан хүмүүсийн түүх, туршлагыг бичиж, сурталчлах;

6.6.16. үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, бичгийн хэрэгсэл бусад эд зүйлсийн хүсэлтийг нөөцийн багт тавьж шийдвэрлүүлэх;

### **6.7. Санхүү, нөөцийн багийн үндсэн чиг үүрэг:**

6.7.1. хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн болон техник, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;

6.7.2. халдварт өвчний хариу арга хэмжээний нөөцийг дайчлах, хуваарилалтыг зохих журмын дагуу зохион байгуулах;

6.7.3. тохиолдлын удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүний болон хариу арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай хүний нөөцийг дайчлан ажиллуулах, хуваарилах;

6.7.4. багуудын болон хариу арга хэмжээнд дайчлагдан ажиллаж буй бие бүрэлдэхүүний ажилласан цагийн тооцоог бүртгэх, цалин, нэмэгдэл хөлс, урамшууллыг тооцож олгох;

6.7.5. багуудыг үйл ажиллагаа хэвийн явуулах байр, техник тоног төхөөрөмжөөр хангаж, дэд бүтцийг бий болгох;

6.7.6. Дайчлагдан ажиллах бие бүрэлдэхүүнийг мөрдөн ажиллах заавар журмаар хангах, түргэвчилсэн сургалт зохион байгуулах;

6.7.7. Өдөр тутмын санхүүгийн тайланг дараа өдрийн хуралд танилцуулах;

6.7.8. Шаардлагатай бичиг баримтыг хувиан олшруулах, тараах, устгах, баримтжуулах, архивлах.

Долоо. ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ ЦУЦАЛСНЫ

ДАРААХ АРГА ХЭМЖЭЭ

7.1. Голомтыг цомхотгосны дараа Ангийн дарга бөгөөд Ерөнхий зохицуулагч ТУТ-г цуцалсан шийдвэрийг гаргана.

7.2. Тохиолдлын удирдлагын тогтолцоог цуцалсан шийдвэрийг хариу арга хэмжээнд оролцсон бүх талуудад менежер мэдээлэх;

7.3. Баг бүр өөрийн үйл ажиллагааны тайлан, зөвлөмж болон санхүүгийн тайланг 7 хоногийн дотор багтаан бэлэн болгох;


7.4. Хариу арга хэмжээг үнэлэх салбар хоорондын үнэлгээний уулзалтыг зохион байгуулах;

7.5. Багуудын үйл ажиллагаанаас гарсан зөвлөмжийг үндэслэн улсын болон орон нутгийн албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөө, албаны ажиллах энэхүү журамд тодотгол хийх;

7.6. Хариу арга хэмжээний бичиг баримтуудыг баримтжуулах, архивлах.




ХҮНИЙ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕИЙН ТУТ-НЫ БҮРЭЛДЭХҮҮН



ЗООНОЗЫН ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕДИЙН АЖИЛЛАХ ТУТ-НЫ БҮРЭЛДЭХҮҮН

Нэгжийн дарга – (Зохицуулагч)  
Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга Т.Алимаа

Нэгжийн орлогч - (Менежер) Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч Ё.Улсболд




№	Албан тушаалтан	Орлох албан тушаалтан
1	Хүний нөөцийн ажиглан, хуулийн зөвлөх Я.Тогтохням	СЭЦХХА албаны дарга Л.Өнөрбаяр
2	Стратеги төлөвлөлт санхүү бүртгэлийн албаны дарга Ч.Батболд	Стратеги төлөвлөлт санхүү бүртгэлийн албаны статистикч Ш.Соёлмөнх
3	МТИП-ийн эрхлэгч Б.Мөнхжаргал	МТИП-ийн мэдээллийн технологийн инженер Ч.Далайцэрэн
4	Технологийн тасгийн эрхлэгч Н.Халиун	Технологийн тасгийн эрхлэгч эмч Б.Оргил
5	Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч М.Цэрэндэвжид	Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч эмч Б.Соёллоо
6	Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч Р.Энхтуяа	Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч эмч н.Дэлгөөн

№	Албан тушаалтан	Орлох албан тушаалтан
1	Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч Г.Цэндбаяр	Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч Х.Мядагмаа
2	Донор зохион байгуулалтын тасгийн нийгмийн ажилтан Д.Дулмаа	Донор зохион байгуулалтын тасгийн олон нийтийн ажилтан Ж.Энхсбат
3	ЧЦССА-ны чанарын менежер Э.Тунгалагуяа	Нэгдсэн лабораторийн лаборант А.Заяабилэг
4	Сувилахуйн албаны дарга Б.Өнөрцэцэг	Донор зохион байгуулалтын тасгийн сувилагч Э.Дашгараа
5	Технологийн тасгийн эрхлэгч Б.Оргил	Технологийн тасгийн сувилагч Б.Золжаргал
6	Нэгдсэн лабораторийн лаборант Э.Отгонжаргал	Нэгдсэн лабораторийн лаборант С.Ганчимэг
7	МТИП-ийн эмнэлгийн инженер Б.Додьгалсан	МТИП-ийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер Ц.Энхмэнд


№	Албан тушаалтан	Орлох албан тушаалтан
1	Нэгдсэн лабораторийн лаборант Д.Энхсүрэн	Нэгдсэн лабораторийн лаборант Н.Тэрбишлогтох
2	Донор зохион байгуулалтын тасгийн сувилагч Э.Золбоо	Донор зохион байгуулалтын тасгийн сувилагч Д.Олмаа
3	Технологийн тасгийн сувилагч нар	Технологийн тасгийн олгох хэсгийн сувилагч нар

№	Албан тушаалтан	Орлох албан тушаалтан
1	Стратеги төлөвлөлт санхүү бүртгэлийн албаны ахлах нягтлан Ө.Бат-Эрдэнэ	Стратеги төлөвлөлт санхүү бүртгэлийн албаны нягтлан П.Оюунтунгалаг
2	Стратеги төлөвлөлт санхүү бүртгэлийн албаны нярав Б.Алтанзул	Стратеги төлөвлөлт санхүү бүртгэлийн албаны туслах ажилтан Ж.Эрхэмбаяр
3	Стратеги төлөвлөлт санхүү бүртгэлийн албаны туслах ажилтан Ж.Эрхэмбаяр	Стратеги төлөвлөлт санхүү бүртгэлийн туслах ажилтан Б.Хаянхярваа


ХООЛ, ХҮНСНИЙ ШАЛТГААНТ ХОРДЛОГЫН ҮЕИЙН ТУТ-НЫ БҮРЭЛДЭХҮҮН



ХИМИ, ЭМ, ЦАЦРАГ ИДЭВХИТ БОДИСЫН ХОРДЛОГЫН ҮЕИЙН ТУТ-НЫ БҮРЭЛДЭХҮҮН



ОЛНЫГ ХАМАРСАН ОСОЛ, ГЭМТЛИЙН ҮЕИЙН ТУТ-НЫ БҮРЭЛДЭХҮҮН



№	Албан тушаалтан	Орлох албан тушаалтан	Орлох албан тушаалтан	Орлох албан тушаалтан	Орлох албан тушаалтан	Орлох албан тушаалтан
1	Хүний нөөцийн ажилтан, хуулийн зөвлөх Я.Топхоням	СЭЦХХА албаны дарга Л.Өнөрбаяр	Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч эмч Р.Энхтуяа Е.Улсболд	Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч эмч Х.Мядагмаа	Нэгдсэн лабораторийн лаборант Д.Энхсүрэн	Стратеги төлөвлөлт санхүү бүртгэлийн албаны ажилтан П.Оюунтулгал
2	Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч Т.Алимаа	Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч эмч Р.Энхтуяа	Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч эмч Х.Мядагмаа	Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч Э.Золбоо	Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч Э.Золбоо	Стратеги төлөвлөлт санхүү бүртгэлийн албаны ажилтан Ө.Бат-Эрдэнэ
3	Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга Т.Алимаа	Нэгдсэн лабораторийн лаборант А.Заяабилэг	ЧЦССА-ны чанарын менежер Э.Тунгалагтуяа	Нэгдсэн лабораторийн лаборант А.Заяабилэг	Технологийн тасгийн сувилагч нар	Стратеги төлөвлөлт санхүү бүртгэлийн албаны нярав Б.Алтанзул
4	МТИПТ-ийн эрхлэгч Б.Мөнхжаргал	МТИПТ-ийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер Ц.Энхмэнд	Сувилгахуйн албаны дарга Б.Өнөрцэцэг	Донор зохион байгуулалтын тасгийн сувилагч Э.Дашгарав	Технологийн тасгийн сувилагч нар	Стратеги төлөвлөлт санхүү бүртгэлийн албаны ажилтан Ж.Эрхэмбаяр
5	Технологийн тасгийн эрхлэгч Н.Халиун	Технологийн тасгийн эрхлэгч эмч Б.Оргил	Технологийн тасгийн эрхлэгч эмч Б.Оргил	Технологийн тасгийн сувилагч Б.Золжаргал	Технологийн тасгийн сувилагч нар	Стратеги төлөвлөлт санхүү бүртгэлийн албаны ажилтан Ж.Эрхэмбаяр
6	Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч М.Цэрэндэжид	Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч эмч Б.Соёлоо	МТИПТ-ийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер Б.Додьгалсан	Нэгдсэн лабораторийн лаборант С.Ганчимэг	Технологийн тасгийн сувилагч нар	Стратеги төлөвлөлт санхүү бүртгэлийн албаны ажилтан Б.Хаянхярваа
7						

## Найм: ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗААВАР

ЦССҮТ-ийн хэмжээнд гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хариу арга хэмжээний дараах зааврын дагуу ажиллана.

ЦССҮТ	ЦССҮТ-ийн холбогдох нэгжүүд	Эрүүл мэндийн яам / Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын алба (ЭМУА)
<i>24 цагийн дотор</i>		
<p>-Бүх ажилчдын аюулгүй байдлыг хангана;</p> <p>-Цусны салбар төвүүдтэй хамтран ажиллах холбоо тогтооно.</p> <p>-Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлын төлөвлөгөө болон үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөөг дараах байдлаар идэвхжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шаардлагатай тохиолдолд тохиолдлын удирдлага хариуцсан зохицуулагч, менежерийг нөхөн томилж, холбоо барих мэдээллийг ангийн гишүүд, холбогдох байгууллагад мэдэгдэнэ</li> <li>- Тохиолдлын удирдлагын нэгжийг идэвхжүүлж, үндсэн чиг үүргийг нь тодорхойлно</li> <li>-Тохиолдлын удирдлагын тогтолцооны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэмэлт хүн хүч дайчлах хүсэлтийг Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албанд гаргана.</li> <li>-Эрт үеийн хариу арга хэмжээний зорилтууд дээр зөвшилцөнө.</li> <li>- Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны нэгжтэй харилцаа холбоо тогтооно.</li> <li>- Эрт үеийн хариу арга хэмжээг эхлүүлж, удирдана.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Нийт нэгжүүдэд: <ul style="list-style-type: none"> <li>- 2 цагийн дотор ажиллагсад төвийн зарласан байрлалд цугларна.</li> <li>- Нийт ажиллагсад мэдээлэл өгөх, бэлэн байдлыг хангуулах</li> <li>- Олон нийтэд чиглэсэн мэдээ мэдээлэл, сурталчилгаа хийх</li> </ul> </li> <li>- ДЗБТ-т: <ul style="list-style-type: none"> <li>- Цус цуглуулах төлөвлөгөө гаргана.</li> <li>- Цусны салбар төвүүдтэй холбогдоно.</li> <li>- Цус цуглуулахад шаардлагатай нөөц, материал хэрэгслийг бэлтгэх</li> </ul> </li> <li>НЛТ-т: <ul style="list-style-type: none"> <li>- Цус цуглуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх</li> <li>- Урвалж, оношлуур, дагалдах хэрэгслийн нөөцийн татан авах</li> <li>- Техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах</li> </ul> </li> <li>ТТ-т: <ul style="list-style-type: none"> <li>- Цус цуглуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх</li> <li>- Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шаардлагатай материал, хэрэгслийн нөөцийн татан авах</li> <li>- Техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах</li> <li>- Цус цусан бүтээгдэхүүний нөөцийн болон хэрэглээний мэдээллийг гаргаж өгөх</li> <li>- Цус цусан бүтээгдэхүүн тээвэрлэхэд шаардлагатай сав, тээврийн хэрэгслийн тооцоолол гаргаж бэлэн байдлыг хангах</li> </ul> </li> <li>СТСБА-нд: <ul style="list-style-type: none"> <li>- ЦССҮТ-ийн нөөцийн мэдээллийг нэгтгэн гаргах</li> <li>- Нөөцийн хуваарилалтыг хийх</li> <li>- Шаардлагатай тохиолдолд нөөцийн татан авалт хийх, нөхөн хангах</li> <li>- Шаардлагатай бэлэн мөнгөний нөөцийг татан авах</li> <li>- Нэг бүрийн болон хамтын хамгаалах хэрэгслийг бэлтгэх, олгох</li> </ul> </li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ЭМУА-ны холбогдох мэргэжилтнийг томилж, түүнтэй холбоо барих мэдээллийг нэгжийн гишүүд, мэргэжлийн төвүүдэд явуулах</li> <li>- Тохиолдлын удирдлага хариуцсан менежерт дэмжлэг үзүүлэх багийг байгуулж, үндсэн чиг үүрэг тус бүрийг хариуцсан багийн гишүүдийг томилно</li> <li>- ГХЭМУА -ны нэгжийн дарга, албаны даргатай зөвшилцөн ОБЕГ, ШСА, УОК бусад байгууллагад зохих журмын дагуу мэдэгдэх (халдвар үүсгэгчээр сэдээгдсэн өндөр буюу маш өндөр эрсдэлтэй 2 буюу 3 дугаар зэрэглэлийн гамшиг)</li> <li>- Улсын онцгой комиссыг хуралдуулах асуудлын талаар холбогдох албан тушаалтантай зөвшилцөж болно</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>- Тээврийн хэрэгсэл, шатах тослох материалын бэлэн байдлыг хангах МТИТТ-т:</li> <li>- Зарлан мэдээлэх техник хэрэгсэл, сүлжээний бэлэн байдлыг хангах</li> <li>- Мэдээллийн технологийн болон шинжилгээ, үйлдвэрлэлийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах</li> <li>- Нөөцийн тоног төхөөрөмжийн ажиллагааг хангах</li> </ul> <p>ХСХ-ын баг, ХЭМАБ-ын зөвлөл: -Ажиллагсад, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг төлөвлөх</p>	
--	---	--

24 – 72 цагийн дотор

<ul style="list-style-type: none"> <li>· Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн газарт цус, цусан бүтээгдэхүүний туслалцаа үзүүлж, эмнэлгийн байгууллагуудтай хамтран ажиллана.</li> <li>· Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны нөөц санд зохих журмын дагуу хүсэлт гаргана</li> <li>· Цус цусан бүтээгдэхүүний цуглуулалтад томилогдсон дайчилгааны багийг хүлээн авч, тохиолдлын удирдлагын тогтолцооны чиг үүргийг зохих журмын дагуу шилжүүлнэ</li> <li>· Хариу арга хэмжээг зохицуулах механизмын талаар цусны салбар төвүүд, ЭМЯ, бусад түншүүдтэй зөвшилцөнө</li> <li>· Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын алба болон Улсын байнгын онцгой комиссын хурал, тусламжийн багийн уулзалтуудад зохицуулагчийг оролцуулна.</li> <li>· Салбар хоорондын түргэвчилсэн үнэлгээний багт ажиллана</li> <li>· Эрт үеийн хариу арга хэмжээний стратеги, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна</li> <li>· Нөхцөл байдлын анхны тайланг гаргана.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>· Тохиолдлын удирдлагын нэгж тус тусын чиг үүргийн дагуу нөөц, эрсдэл, хүн, хүчний байдал, бололцоо, нөхцөл байдлын мэдээг шуурхай нэгтгэж өдөрт 2 удаа мэдээлнэ</li> <li>· Шаардлагатай тохиолдолд тус тусын чиг үүрэгтэй холбоотой эрсдэлийн үнэлгээ хийнэ.</li> <li>· Төлөвлөлтийн багт үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан төлөвлөлтөд тодотгол хийх</li> <li>· Нийт ажиллагсад нөхцөл байдлын мэдээлэл өгөх,</li> <li>· Олон нийтэд чиглэсэн мэдээ мэдээлэл, сурталчилгаа хийх</li> <li>· ДЗБТ-т: <ul style="list-style-type: none"> <li>• Цус цуглуулах төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.</li> <li>• Цусны салбар төвүүдтэй хамтран ажиллана.</li> </ul> </li> <li>· Цус цуглуулахад шаардлагатай нөөц, материал хэрэгслийг нөхөн хангах</li> <li>НЛТ-т: <ul style="list-style-type: none"> <li>• Цус цуглуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх</li> <li>• Урвалж, оношлуур, дагалдах хэрэгслийн нөөцийг нөхөн хангах</li> <li>• Техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах</li> <li>• Цус цуглуулахын өмнө хийгдэх шинжилгээг хийх</li> <li>• Донороос цуглуулсан цусанд цусаар дамжих халдвар, цусны бүлэг тодорхойлох шинжилгээг хийж хариуг олгох.</li> </ul> </li> <li>ТТ-т: <ul style="list-style-type: none"> <li>-Цус цуглуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх</li> <li>• Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шаардлагатай материал, хэрэгслийн нөөцийн нөхөн хангалт хийх</li> <li>• Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах</li> </ul> </li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>· Тохиолдлын удирдлага хариуцсан менежерт дэмжлэг үзүүлэх багийг албажуулж, үндсэн чиг үүрэг тус бүрийг хариуцсан багийн гишүүдийг баталгаажуулна</li> <li>· Нөөц дайчлах, мэргэжил арга зүйн болон үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх талаар АНЭМА, төрөлжсөн мэргэжлийн төвөөс илрүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулна</li> <li>· Шаардлагатай бол харилцаа холбоо, хэвлэлийн мэдээлэл гаргах асуудлаар ТМТ д дэмжлэг үзүүлнэ</li> <li>· ЭМУА - ны нөөцийг дайчлах шийдвэр гаргах</li> <li>· Шаардлагатай тохиолдолд Гамшгийн улсын нөөцөөс хөрөнгө, эд материал гаргуулах хүсэлтээ ОБЕГ, ОУК т тавьж шийдвэрлүүлэх</li> <li>· Үндэсний болон ОУын хэмжээнд хандивлагч нарт сэрэмжлүүлэг хүргэнэ</li> <li>· Удирдлагуудыг мэдээллээр тогтмол хангаж ажиллана</li> <li>· НҮ - ний төрөлжсөн байгууллагууд Эрүүл мэнд, хоол тэжээл, ус, ариун цэвэр, халдвартгүйтгэлийн кластерийн үйл ажиллагаа чиглүүлэн хамтран ажиллана.</li> </ul>
--	---	--

